**МОНГОЛ УЛСЫН**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2021 оны 12 сарын 13 өдөр Дугаар А/780 Улаанбаатар хот

"Эрүүл, идэвхтэй амьдрал" 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.6 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Эрүүл, идэвхтэй амьдрал" 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг нэгдүгээр, шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсугай.

2. "Эрүүл идэвхтэй амьдрал" 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар (Д.Баярболд), Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар (Б.Буянтогтох)-т, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөвт тусгах, Эрүүл мэндийг дэмжих сангаас санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн газар (Б.Мөнхтуул)-т, хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Д.Нарантуяа)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган ажиллахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төр, хувийн хэвшлийн бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр)-т тус тус даалгасугай.

САЙД С.ЭНХБОЛД

14121354

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 сарын 13 өдрийн А/780 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# “ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ” 2021-2024 ОНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

**ЗОРИЛГО:** Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дэмжиж, иргэн бүрт эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх

**ЗОРИЛТ:**

1. Эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжсэн тогтолцооны чиглэлээр бодлого, эрх зүйн орчинг сайжруулах
2. Эрүүл, идэвхтэй амьдралыг дэмжсэн дэд бүтцийг хүн амын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй болгох
3. Эрүүл, идэвхтэй хөдөлгөөнийг эрхэмлэх нийгмийн сэтгэлзүйг төлөвшүүлэх
4. Эрүүл зөв зохистой хооллолтыг дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх
5. Сэтгэц, зан үйл, танин мэдэхүйн эрүүл мэндийг дэмжсэн нийгмийн орчинг бүрдүүлэх

| | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хэрэгжих хугацаа, арга хэмжээ | | | | Хариуцах байгууллага | Хамтрах байгууллага | Төсөв (сая) |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | | | |
| **ЗОРИЛТ 1. ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫГ ДЭМЖСЭН ТОГТОЛЦООНЫ ЧИГЛЭЛЭЭР БОДЛОГО, ЭРХЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ** | | | | | | | | |
| 1. | Идэвхтэй хөдөлгөөний үндэсний удирдамж, дасгал хөдөлгөөний цахим жорыг хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн байдалд тохируулан боловсруулах | ЭМС, БТСУХ-ны даргын хамтарсан тушаал гарсан байна. | Үндэсний удирдамж хэрэгжиж эхэлсэн байна. | Үндэсний хэмжээнд сургалт, сурталчилгааг зохион байгуулсан байна. | Удирдамжийн хэрэгжилтэд хөндлөнгийн, жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ хийсэн байна | НЭМҮТ БТСУХ | АНЭМГ АНБТСГ | ОУБ, ЭМДС |
| 2. | Цэцэрлэг, ЕБС-д хүүхдийн биеийн жин, таргалалтыг хянах, цахимаар мэдээлэх тогтолцоо бий болгох | Эрүүл мэнд, БШУ-ны сайдын 2019 оны А/514,А736 тушаалыг хэрэгжүүлэх хамтарсан уулзалт зохион байгуулсан байна. | Тогтолцоог бий болгоход шаардагдах сургалтын материал, компьютер, програм хангамжийг хийгдсэн байна. | Цэцэрлэг, ЕБС-д хүүхдийн биеийн жин, таргалалтыг хянах, цахимаар мэдээлэх тогтолцоо бүрдүүлсэн байна. | Эрүүл мэнд, БШУ-ны сайдын 2019 оны А/514, А736 тушаалыг хэрэгжүүлэх хамтарсан уулзалт зохион байгуулсан байна. | Тогтолцоог бий болгоход шаардагдах сургалтын материал, компьютер, програм хангамжаар хангасан байна. | АНЭМГ АНБГ | ОУБ, ЭМДС |
| 3. | Цэцэрлэг, сургуулийн хичээлийн болон хичээлийн бус цагаар хүүхдийн хөдөлгөөний идэвхийг | | Хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан байна. | Удирдамжийг бүх шатны боловсролын байгууллагууд | Удирдамжийн хэрэгжилтийг жил бүр үнэлж, үйл ажиллагаа | ЭМЯ БШУЯ БТСУХ | АНБГ | Хариуцах байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулах удирдамж боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | | Удирдамжийг боловсролын байгууллагуудад түгээгдсэн байна. | хэрэглэж эхэлсэн байна. | тогтмолжсон байна. | | | |
| 4. | Их, дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн оюутнуудад зориулсан спортын арга хэмжээний нэр төрлийг охид, хөвгүүдийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн өргөжүүлэх | | Охид, хөвгүүдийн спортын арга хэмжээний ялгаатай хэрэгцээг илрүүлэх судалгааг хийж, зөвлөмж боловсруулсан байна. | Судалгааны зөвлөмжид тулгуурлан нийцүүлэн спортын арга хэмжээг зохион байгуулсан байна. | Спортлог оюутан, анги танхим, сургууль хамт олныг шалгаруулж, сайн туршлагыг сурталчлах ажил зохион байгуулагдсан байна | НЭМҮТ БШУЯ БТСУХ | АНЭМГ АНЗДТГ АНБГ АНБТСГ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 5. | Ажил мэргэжлийн ангилал, онцлогт тохирох дасгал хөдөлгөөний загварыг боловсруулж аж ахуйн нэгж, албан байгууллагуудад түгээх, сурталчлах | | Ажлын байрны дасгал хөдөлгөөний загварыг боловсруулж батлуулсан байна. | Дасгал хөдөлгөөний загварыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тогтмол түгээсэн байна. | Дасгал хөдөлгөөнийг тогтмолжуулсан байгууллагыг олон нийтэд сурталчилсан байна. | ЭМЯ БТСУХ | АНБТСГ | Хариуцах байгууллагын төсөв |
| 6. | Биеийн тамир, спортын хуулийн дагуу идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх олон нийтийн үүсгэл, санаачилгыг дэмжин хөгжүүлэх, оролцоо идэвхийг үнэлсэн механизм бүрдүүлэх, магадлан итгэмжлэлд тусгах | | Ажлын үр дүнг үнэлэх, уралдаан тэмцээний төрөл, журам заавар батлах | Идэвхтэй хөдөлгөөний клуб, нэгжийг байгуулах, үнэлэх, тэмцээн, арга хэмжээ зохион байгуулах, урамшуулах | Идэвхтэй хөдөлгөөний клуб, нэгжийг үнэлэх, тэмцээн, арга хэмжээ зохион байгуулах, урамшуулах | БТСУХ ЭМДЕГ | Аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, БТС-ын газар, хороод | Хариуцах байгууллагын төсөв |
| 7. | Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх үндэсний чадавхийг бүрдүүлэх | | Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулсан байна. | Үндэсний сургагч багш бэлтгэгдэж, сургалт зохион байгуулсан байна. | Сургалтуудыг орон нутагт бүсчлэн зохион байгуулсан байна. | ЭМЯ НЭМҮТ ЭМХТ | Жендэрийн үндэсний хороо | ОУБ |
| 8. | Эрүүл зөв дадал хэвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ажил мэргэжлийн ангиллыг бий болгох | | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, ажил мэргэжилд үнэлгээ хийсэн байна. | Ажил мэргэжлийн ангилалд шинээр тусгах саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлсэн байна. | Эрүүл зөв дадал хэвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн үнэмлэх бүхий багш нар бэлтгэгдсэн | ЭМЯ ХНХЯ БТСУХ | Боловсролын хүрээлэн | ОУБ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна. | | | |
| 9. | Аймаг, сум, дүүрэг, хороо бүрт иргэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг хийх зэрэг цогц үйлчилгээ авах боломж бүхий "Эрүүл зөв амьдрал" жижиг төвүүдийг төр, хувийн хэвшлийн оролцоотой ажиллуулах ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Орон нутагт хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх "Эрүүл зөв амьдрал" төвийг ажиллах асуудлаар шийдвэр гаргагч нарын дунд улсын зөвлөгөөн зохион байгуулсан байна. | "Эрүүл зөв амьдрал" төвийг ажиллуулах бэлтгэлийг хангаж, аймаг дүүрэг бүрт ажиллуулж эхэлсэн байна. | "Эрүүл зөв амьдрал" төвийн үйл ажиллагаа тогтмолжиж, сайн туршлагыг олон нийтэд танилцуулсан байна. | АНЭМГ АНБТСГ | АНЗДТГ АНБТСГ Дүүргийн ЗДТГ ХАҮТ | Хариуцах байгууллагын төсөв |
| 10. | Хэт чихэрлэг хүнсний бүтээгдэхүүн,түүний бүтцэд орох материалд онцгой албан татвар, гаалийн татвар, худалдааны татварын хэмжээг нэмэх хуулийн төсөл боловсруулж батлуулах | | Ажлын хэсэг байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлага, нөлөөллийн судалгааг хийсэн байна. | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн байна. | Хуулийн төслийг батлуулахад шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | ЭМЯ СЯ | НЭМҮТ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>30 сая |
| 11. | Ханасан тос, транс тос, чихэр, давсны агууламж ихтэй эрүүл бус хүнсний зар сурталчилгааг хязгаарлах эрх зүйн зохицуулалтыг бий болгох | | Ажлын хэсэг байгуулж, хуулийн төслийн хэрэгцээ шаардлага, нөлөөллийн судалгааг хийсэн байна. | Хуулийн төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлсэн байна. | Хуулийн төслийг батлуулахад шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. | ЭМЯ | НЭМҮТ ШӨХТГ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>30 сая |
| 12. | ЕБС-ийн "Үдийн хоол"-ны стандартыг боловсруулах | | Стандарт боловсруулах хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, стандартын төслийг боловсруулж, батлуулсан байна. | ЕБС-ийн "Үдийн хоол"-ны стандартыг хэрэгжүүлж эхэлсэн байна. | ЕБС-ийн "Үдийн хоол"-ны стандартын хэрэгжилт тогтмолжсон байна. | ЭМЯ БШУЯ ХХАХҮЯ | НЭМҮТ ОУБ | Хариуцах байгууллагын төсөв |
| 13. | Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын | | | Судалгааны аргачлалыг боловсруулж | Судалгааны ажлыг зохион байгуулж, тайлан, зөвлөмж | ЭМЯ НЭМҮТ | Сонгосон судалгааны байгууллага | Эрүүл мэндийг дэмжих |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | үндэсний V судалгаа хийсэн байна. | | | батлуулсан байна. | гарсан байна. | | | сан 50 сая |
| 14. | Хүн амын хоол тэжээлийн үндэсний VI судалгаа хийх | | | Судалгааны аргачлалыг боловсруулж батлуулсан байна. | Судалгааны ажлыг зохион байгуулж, тайлан, зөвлөмж гарсан байна. | ЭМЯ НЭМҮТ | Сонгосон судалгааны байгууллага | Эрүүл мэндийг дэмжих сан 50 сая |
| 15. | Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийн тархалтын судалгаа хийх | | Судалгаа хийх арга арга зүйгээ боловсруулж, бэлтгэлийг хангасан байна. | Судалгааны мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна. | Судалгааны тайлан, зөвлөмж гарч, шийдвэр гаргагч нарт хүргүүлсэн байна. | ЭМЯ СЭМҮТ | Судалгааны баг | Эрүүл мэндийг дэмжих сан 50 сая |
| 16. | 60-аас дээш насны иргэдэд эрүүл мэнд, нийгэм, сэтгэцийн цогц үнэлгээний аргаар үйл ажиллагааны чадвар бууралтыг эрт илрүүлэх тандалт судалгаа хийх | | Тандалт судалгааны удирдамж батлуулах | Цогц үнэлгээ хийх арга зүйг шинэчилж батлуулна. Улсын хэмжээнд настны мэргэшсэн эмч нарт үнэлгээний арга зүйд сургана. | 60-аас дээш насны иргэдийн 50-иас доошгүй хувийг хамруулсан байна. | ЭМЯ, ГҮТ | Аймаг нийслэлийн ЭМГ ТББ | Эрүүл мэндийг дэмжих 50 сая |
| 17. | Мэдээллийн технологийн апп ашиглан, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, хянах туршилт судалгаа | | Судалгаа хийх арга арга зүйгээ боловсруулах | Судалгааны чиглэлээр эмч нарыг сургах | Судалгаа хийх Судалгааны үр дүнг хүлээлгэн өгөх, түгээх | АШУҮИС НЭМС | СЭМҮТ | 20 сая |
| 18. | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний зардлыг ЭМД-аас санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | | Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний өртөг зардлын судалгаа хийсэн байна. | Судалгааны тайлан, зөвлөмж танилцуулах уулзалт зохион байгуулсан байна. | Судалгааны тайлан, зөвлөмжийг ЭМДҮЗ-ийн ажлын албанд хүргүүлсэн байна. | ЭМЯ СЭМҮТ | БШУЯ ХНХЯ | Эрүүл мэндийг дэмжих сан 20 сая |
| 19. | Нийгмийн эрүүл мэндийн төсвийг төлөвлөх аргачлал боловсруулж, шийдвэрлүүлэх | | Судалгаа хийх үндэслэл, хэрэгжих арга хэлбэрийг боловсруулах | Аргачлал боловсруулах, зөвшилцөх уулзалт зохион байгуулах | СЯ-аар шийдүүлэх | ЭМЯ | СЯ, ТББ Ажлын хэсэг | Хариуцах байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛТ 2. ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛЫГ ДЭМЖСЭН ДЭД БҮТЦИЙГ ХҮН АМЫН ЯЛГААТАЙ ХЭРЭГЦЭЭНД НИЙЦҮҮЛЭН ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОХ** | | | | | | | | |
| 20. | Хүн амын эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдах эрүүл мэндийг дэмжих эрт илрүүлгийн төвийг байгуулах | | Эрт илрүүлгийн төвийн бүтэц, үйл ажиллагааны үлгэрчилсэн загвар боловсруулсан байна. | Эрт илрүүлгийн төв байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлж эхэлсэн байна. | Эрт илрүүлгийн төвийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | ЭМЯ АНЭМГ | ЭМБ | Хариуцах байгууллагын төсөв |
| 21. | Цэцэрлэг, ЕБС-д хүүхдийн бие бялдрын хөгжлийг хянах мэдээллийн цахим тогтолцоо бий болгох | | Мэдээллийн цахим дэд бүтэц, програм хангамж бэлэн болсон байна. | Цахим мэдээллийн сан бүрдсэн байна. | Цахим дэд бүтцийн үйл ажиллагаа жигдэрсэн байна. | ЭМЯ БШУЯ | НЭМҮТ Боловсролын хүрээлэн | Хариуцах байгууллагын төсөв |
| 22. | Оюутан, сурагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг тогтмолжуулж, мэдээллийн цахим дэд тогтолцоо бий болгох | | Үзлэг шинжилгээг хамтран зохион байгуулж, үр дүнг тооцох цахим мэдээллийн санг үүсгэсэн байна. | Үзлэг шинжилгээг зохион байгуулж, цахим сангийн үйл ажиллагаа тогтмолжиж, үр дүнг тооцсон байна. | Үзлэг шинжилгээг зохион байгуулж, цахим сангийн үйл ажиллагаа тогтмолжиж, үр дүнг тооцсон байна | ЭМЯ БШУЯ | АНЭМГАНБГ | Хариуцах байгууллагын төсөв |
| 23. | Настанд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээг төрөл бүрийн хэлбэрээр өргөжүүлж тэднийг нийгэм хамт олон дунд сэргээн засах төвүүдийг нэмэгдүүлэх | | Хамт олонд түшиглэсэн сэргээн засах төв шинээр байгуулагдсан байна. | Настанд үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө үзлэг, үйлчилгээний тоог нэмэгдсэн байна. | Настанд үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө үзлэг, үйлчилгээний тоог нэмэгдсэн байна. | ЭМЯ, Геронто логийн үндэсний төв | СЭМҮТ ЭМДЕГ | Хариуцах байгууллагын төсөв |
| 24. | Хүн амыг эрүүл, идэвхтэй амьдралын талаар нотолгоонд суурилсан албан ёсны мэдээллээр хангах “Эрүүл идэвхтэй амьдрал” веб хуудас ажиллуулж, нийгмийн сүлжээний бүх сувгаар түгээх | | Веб хуудас боловсруулах хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан байна. | Веб хуудас ажиллаж, холбоос нь бүх шатны эрүүл мэндийн байгууллагын веб хуудсанд байрласан байна. | Веб хуудасны хэрэглээ нэмэгдсэн байна. | ЭМЯ НЭМҮТ | ЭМБ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>30 сая |
| 25. | Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагын веб | | Судлан агуулга тодорхойлогдож, | Веб сайтад “Эмч зөвлөж байна” | Веб сайтад “Эмч зөвлөж байна” линк | ЭМЯ НЭМҮТ | Аймаг, нийслэлийн | Эрүүл мэндийг |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайтад “Эмч зөвлөж байна” линк үүсгэн эмч нарын зөвлөгөө, шинэ дэвшилтэт технологи, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл, яриа лекцийг тогтмол тавьж ажиллуулах | | линк үүсгэх ажиллагааны үндэс суурь тавигдсан байна. Эмч нарын баг төлөөлөл бүрдсэн байна | линк үүсгэн тогтмолжиж, иргэдийн санал хүсэлтийн мэдээний сан үүссэн байна. | үүсгэн тогтмолжиж, иргэдийн санал хүсэлтийн мэдээний сан үүссэн байна | | Эрүүл мэндийн бүх байгууллагууд | дэмжих сан<br>30 сая |
| 26. | ЕБС-ийн орчны эрүүл ахуй,аюулгүй байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх | | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, үнэлгээний аргачлалыг батлуулсан байна. | ЕБС-ийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг үнэлгээ хийж, зөвлөмж гаргасан байна. | Зөвлөмжийг ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн байна. | ЭМЯ МХЕГ | БШУЯ ЕБС | Хариуцах байгууллагын төсөв |
| 27. | Эрүүл мэндийн боловсролын чанар, үр дүн сайжруулах, эрүүл мэндийг дэмжигч сургуулийн үйл ажиллагааг олон нийтэд таниулан сурталчлах | | Эрүүл мэндийг дэмжигч сургууль удирдамжийг шинэчлэх, гарын авлага хэвлэх, ажлыг эрчимжүүлсэн байна. | Эрүүл мэндийг дэмжигч сургууль шалгаруулж, шагнах, алдаршуулсан байна. | Эрүүл мэндийг дэмжигч сургууль шалгаруулж, шагнах, алдаршуулсан байна. | ЭМЯ БШУЯ | ЕБС-иуд | Эрүүл мэндийг дэмжих сан<br>60 сая |
| 28. | Хот суурин газрын төлөвлөлтөд явган алхах, дугуй унах аюулгүй, таатай нөхцөлийг хүртээмжтэй бүрдүүлэх ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Явган алхах, дугуй унах замын хүртээмж, аюулгүй байдлын тандалт судалгааг хийж, шаардлагатай төсөл арга хэмжээг олон нийтийн дунд танилцуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн төлөвлөлтөд тусгах арга хэмжээний талаар ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийн төлөвлөлтөд тусгах арга хэмжээний талаар ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | ЭМЯ БХБЯ | АНЗДТГ | Эрүүл мэндийг дэмжих сан<br>Орон нутгийн төсөв |
| 29. | Нийтийн зориулалттай биеийн тамир, чийрэгжүүлэлтийн заал, талбайг аймаг, дүүрэг бүрт бий болгох | | Дасгал хөдөлгөөний заал, талбайн хүртээмжийн тооцооллыг гаргаж, нийтлэг шаардлагыг тогтоосон байна. | Орон нутгийн шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийг өргөн хүрээтэй зохион байгуулсан байна. | Нийтлэг шаардлагад нийцсэн дасгал хөдөлгөөний заал, талбай байгуулсан сайн туршлагыг сурталчилсан байна. | ЭМЯ БТСУХ АНЭМГ | АНЗДТГ НЭМҮТ | Эрүүл мэндийг дэмжих сан<br>Орон нутгийн төсөв |
| 30. | Явган алхах зам маршрутыг хүртээмжтэй болгож, | | Явган алхах замын | Орон нутгийн шийдвэр гаргагч | Явган алхах маршрутыг шинээр | ЭМЯ БТСУХ | АНЗДТГ НЭМҮТ | Орон |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн тохижолт үйлчилгээний дэд бүтцийг бий болгох | | хүртээмжийн тооцооллыг гаргаж, нийтлэг шаардлагыг тогтоосон байна | нарт ухуулга нөлөөллийг өргөн хүрээтэй зохион байгуулсан байна. | байгуулсан сайн туршлагыг сурталчилсан байна. | АНЭМГ | | нутгийн төсөв |
| 31. | Нийтийн үйлчилгээ үзүүлдэг дасгал хөдөлгөөн, эрүүл хооллолтын клуб, төвүүдийн үйл ажиллагааг дэмжих цогцолбор байгууламж байгуулах хөдөлгөөнийг өрнүүлэх | | Нийтийн дасгал хөдөлгөөний түрээсгүй үйлчилгээг дэмжих ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байна. | Улс төр, олон нийт, бизнесийн байгууллагад уриалга гаргаж, зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан байна. | Нийтийн дасгал хөдөлгөөний түрээсгүй үйлчилгээтэй орон нутгийн сайн туршлагыг сурталчилсан байна. | ЭМЯ БХБЯ БТСУХ | АНЗДТГ НЭМҮТ | Орон нутгийн төсөв |
| 32. | Иргэн өөрийнхөө идэвхтэй хөдөлгөөн, бие бялдрын үзүүлэлт, эрүүл хоололтыг хянах гар утасны аппликейшн монгол хэлээр хөгжүүлж түгээх | | Гар утасны аппликейшн боловсруулж, туршин нэвтрүүлсэн байна. | Хэрэглээг сурталчилж түгээн дэлгэрүүлнэ. | Хэрэглээнд нэвтэрсэн байна. | НЭМҮТ БТСУХ | Мэдээлэл харилцаа холбооны газар | ОУБ |
| 33. | Эрүүл идэвхтэй амьдралыг дэмжсэн дэд бүтцийн салбар дундын зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулах | | Хамтарсан ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөөний дагуу зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангасан байна. | Салбар дундын зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулагдсан байна. | Салбар дундын зөвлөгөөн, үзэсгэлэн зохион байгуулах ажил тогтмолжсон байна. | ЭМЯ, БХБЯ ЗТХЯ | АНЗДТГ ХАҮТААН | Эрүүл мэндийг дэмжих сан |
| **ЗОРИЛТ 3. ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ ХӨДӨЛГӨӨНИЙГ ЭРХЭМЛЭХ НИЙГМИЙН СЭТГЭЛЗҮЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 34. | Эрүүл аж төрөх, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны талаарх Засгийн газрын 2001 оны 224 дүгээр тогтоолыг өөрчлөн шинэчлэн хэрэгжүүлэх | | Засгийн газрын тогтоолыг шинэчлэн батлуулсан байна. | Эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны зохицуулалт сайжирч, тогтмолжсон байна. | Эрүүл мэндийн мэдээлэл сурталчилгааны зохицуулалт сайжирч, тогтмолжсон байна. | ЭМЯ НЭМҮТ | ЭМБ | Хариуцах байгууллагын төсөв |
| 35. | Хөгжлийн бэрхшээлийн онцлогт тохирсон дасгал хөдөлгөөн, түүний ач холбогдлын талаар олон нийтэд хүргэх | | Цахим сургалтын модуль боловсруулсан байна. | Цахим сургалт зохион байгуулсан байна. | Цахим сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ БТСУХ | ХБХХЕГ | Хариуцах байгууллагын төсөв |
| 36. | Ахмад настнуудын спортын баг, хамтлаг, сонирхлын бүлэг, клуб байгуулах | | Хамтарсан арга хэмжээний удирдамжийг | Хамтарсан арга хэмжээний удирдамжийг | Хамтарсан арга хэмжээний удирдамжийг | Геронтологийн үндэсний төв | БТСУХ Монголын Ахмадын | Хариуцах байгууллагын |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | санаачилгыг дэмжих, тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | | батлуулж хэрэгжүүлсэн байна. | батлуулж хэрэгжүүлсэн байна. | батлуулж хэрэгжүүлсэн байна. | | Холбоо | төсөв |
| 37. | Жирэмсэн, хөхүүл ээж нар хийх дасгал хөдөлгөөнөөр хичээллэх цахим зөвлөгөө, сургалт зохион байгуулах | | Дасгал хөдөлгөөний цахим зөвлөгөө боловсруулж, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан байна. | Цахим зөвлөгөө, сургалтыг нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан байна. | Цахим зөвлөгөө, сургалтыг нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулсан байна. | ЭМЯ ЭХЭМҮТ | АНЭМГ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>20 сая |
| 38. | Сахар, жин өндөр, БЖИ, А/Д, эрдэс бодисын түвшинг цогцоор нь хэмжих төхөөрөмж, оношлуураар өрх, тосгоны эрүүл мэндийн төв, НЭМТ-ийг хангах, цахим холболт хийх | | Өрх, тосгоны эрүүл мэндийн төвүүдийг бодисын солилцоо бие бялдрын үзүүлэлт хэмжих төхөөрөмж, оношлуураар хангасан байна. | Сумын эрүүл мэндийн төв, НЭМТ-ийг бие бодисын солилцоо бялдрын үзүүлэлт хэмжих төхөөрөмж, оношлуураар хангасан байна. | Бодисын солилцоо бие бялдрын үзүүлэлтийн мэдээллийг нэгтгэх цахим тогтолцоо бүрдүүлсэн байна. | ЭМЯ, НЭМҮТ | АНЭМГ ӨСЭМТ | Улсын төсөв<br><br>ОУБ |
| 39. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн ахмадын дасгал хөдөлгөөний сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцох | | Сургалтын агуулга, модулийг холбогдох сайд нарын тушаалаар батлуулж, сургагч багш нарыг бэлтгэсэн байна. | Сургалтын үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Сургалтын үйл ажиллагаа үргэлжилж, үр дүнг тооцож дүгнэдэг болсон байна. | НЭМҮТ Геронтологийн үндэсний төв ХХҮЕГ | ХНХЯ БТСУХ Монголын Ахмадын Холбоо | Хариуцах байгууллагын төсөв |
| 40. | Биеийн тамир, спортоор хичээллэхэд бие физиологид гарах өөрчлөлт, хяналт тавих, эрдэс бодис, витамин, хоолоор нөхөн сэргээх талаар зөвлөмж боловсруулах | | Хүн амын бүлэг бүрт тохирсон зөвлөмж боловсруулж, сургалтын агуулгад оруулсан байна. | Сургалтын үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Сургалтын үйл ажиллагаа үргэлжилж, үр дүнг тооцож дүгнэдэг болсон байна. | НЭМҮТ БТСУХ | Спортын АУ төв, АНБТСГ | Хариуцах байгууллагын төсөв |
| 41. | Ерөнхий сайдын нэрэмжит "Иргэд эрүүл аж төрөхөд ээлтэй аймаг, дүүрэг, сум, хороо хөдөлгөөн" өрнүүлж жил бүр дүгнэх, урамшуулах, алдаршуулах | | "Хөдөлгөөн" өрнүүлж жил бүр дүгнэх, урамшуулах, алдаршуулсан байна. | "Хөдөлгөөн" өрнүүлж жил бүр дүгнэх, урамшуулах, алдаршуулсан | "Хөдөлгөөн" өрнүүлж жил бүр дүгнэх, урамшуулах, алдаршуулсан | ЭМЯ АНЗДТГ | АНЭМГ АНЗДТ-ын харьяа байгууллагууд | Хариуцах байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | байна. | | | |
| 42. | Монгол улсын "Үндэсний алхалтын өдөр"-ийг зохион байгуулах | | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | НЭМҮТ | БТСУХ | Эрүүл мэндийг дэмжих сан 10.0 |
| 43. | Монгол улсын "Автомашингүй өдөр "-ийг зохион байгуулах | | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | ЭМЯ АНЭМГ | НЭМҮТ БТСУХ ТЦГ | Эрүүл мэндийг дэмжих сан 10.0 |
| 44. | Олон нийтийн оролцоонд түшиглэсэн дасгал хөдөлгөөн, бүжиг, иог, алхалт, гүйлт, дугуйн болон бусад идэвхтэй хөдөлгөөнийг дэмжсэн дэлхийн болон үндэсний өдрийг тэмдэглэхэд дэмждэг үзүүлэх | | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Олон нийтэд ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | АНЭМГ | АНЗДТГ Мэргэжлийн холбоод | Хариуцах байгууллагын төсөв |
| **ЗОРИЛТ 4. ЭРҮҮЛ, ЗӨВ, ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТЫГ ДЭМЖСЭН НИЙГМИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 45. | Эхийн сүүгээр дагнан хооллох зан үйлийг төлөвшүүлэх санамж, зурагт хуудас, ТВ шторк, конент боловсруулж, сурталчлах | Мэдээлэл сурталчилгааны материал боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхээс гадна өрх, сум, тосгоны ЭМТ-өөр дамжуулан сургалт зохион байгуулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхээс гадна өрх, сум, тосгоны ЭМТ-өөр дамжуулан сургалт зохион байгуулсан байна.. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээхээс гадна өрх, сум, тосгоны ЭМТ-өөр дамжуулан сургалт зохион байгуулсан байна. | НЭМҮТ | АНЭМГ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 46. | Саажилттай хүүхдэд зориулсан хоолны жорыг хүүхдийн байгууллага, тусгай цэцэрлэгт нэвтрүүлж, хооллоход зориулсан тусгай хэрэгслээр хангах | Хоолны жорыг боловсруулсан байна. | Хүүхдийн байгууллага, тусгай цэцэрлэгт сургалт зохион байгуулсан байна. | Хүүхдийн байгууллага, тусгай цэцэрлэгт нэвтрүүлж, тусгай хэрэгслээр хангах | Саажилттай хүүхдэд зориулсан хоолны жорны хэрэглээ тогтмолжсон байна. | ЭМЯ БШУЯ | АНЭМГ АНБГ | Хариуцах байгууллагын төсөв |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 47. | Хоол хүнс үйлдвэрлэгч нарт хүнсний аюулгүй байдлын талаар сургалт явуулах | | Сургалтын хамтарсан хөтөлбөр батлуулж сургалт зохион байгуулсан байна. | Хамтарсан сургалт зохион байгуулсан байна. | Хамтарсан сургалт зохион байгуулсан байна. | НЭМҮТ МХЕГ | АНЭМГ | Хариуцах байгууллагын төсөв |
| 48. | Хүнсний аюулгүй байдлыг хангах талаар олон нийтэд чиглэсэн ухуулга нөлөөллийн арга хэмжээг хамтран зохион байгуулах | | Хамтарсан удирдамж, төлөвлөгөө батлуулсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна. | НЭМҮТ МХЕГ | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар | Хариуцах байгууллагын төсөв |
| 49. | Ил задгай зах, дэлгүүрт зарагдаж байгаа хүнсний бүтээгдэхүүний найрлага, эрдэс бодисыг жилд 2-3 удаа тогтмол судлах | | Судалгааны аргачлал, хамрах хүрээ батлагдсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна. | НЭМҮТ МХЕГ | Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар | Хариуцах байгууллагын төсөв |
| 50. | Хүн амын насны бүлэг, өвөрмөц бүлэг бүрт тохирсон зохистой хооллолтын зөвлөгөө өгөх контент боловсруулах, түгээх | | Зохистой хооллолтын контент боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээсэн байна. | НЭМҮТ | АНЭМГ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 51. | Баяжуулсан гурил, иоджуулсан давсны эрүүл мэндийн ач тусыг сурталчлан таниулах мэдээлэл харилцааг өргөжүүлэх | Мэдээлэл сурталчилгааны материал боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | НЭМҮТ | ХХААХҮЯ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 52. | Далд өлсгөлөн (А, Д аминдэм, төмөр, цайр, селен)-гөөс сэргийлэх мэдээлэл харилцааг зохион байгуулах | Мэдээлэл сурталчилгааны материал боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 53. | Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын ажилтнуудад хоол, хүнсний илчлэг, шимт бодисын хэмжээг тооцох сургалтыг зохион байгуулах | Сургалтын хөтөлбөр, арга зүй боловсруулсан байна. | Сургалтын хөтөлбөр батлуулж сургалт зохион байгуулсан байна. | Сургалтыг бүсчлэн зохион байгуулсан байна. | Сургалтыг бүсчлэн зохион байгуулсан байна. | НЭМҮТ | ХХААЯ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 54. | Хүнсний бүтээгдэхүүний шошгын мэдээллийг ашиглан эрүүл хүнс сонгон хэрэглэх, давсны хэрэглээг бууруулах сурталчилгаа хийх | Мэдээлэл сурталчилгааны материал боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн ЭМГ | Эрүүл мэндийг дэмжих сан<br>10 сая |
| 55. | "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай" хууль, ЕБС-ийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх | | Хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, удирдамж, төлөвлөгөө батлагдсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна. | Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гарсан байна. | НЭМҮТ<br>МХЕГ | ЭМЯ,<br>БШУЯ | Хариуцах байгууллагын төсөв |
| 56. | Иргэдэд эрүүл зохистой хооллолтын зөвлөгөө өгөх гарын авлага, зурагт хуудсаар эрүүл мэндийн байгууллагыг хангах | | Иргэдэд зөвлөгөө өгөх гарын авлага, зурагт хуудсыг боловсруулсан байна. | Эрүүл мэндийн анхан шатлалын байгууллагуудыг гарын авлага, зурагт хуудсаар хангасан байна. | Нийгмийн эрүүл мэндийн төв, эрүүл хооллолтын төвүүдийг гарын авлага, зурагт хуудсаар хангасан байна. | НЭМҮТ АНЭМГ | ЭМБ<br>ТББ | Эрүүл мэндийг дэмжих сан<br>20 сая |
| 57. | Нийслэл, орон нутгийн төсвөөс эрүүл идэвхтэй амьдралыг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээнд зарцуулах талаар шийдвэр гаргагч нарт ухуулга нөлөөллийн ажлыг зохион байгуулах | | Нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо, орон нутгийн төсвийн төлөвлөлтөд тусгах арга хэмжээний талаар хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан байна. | Хамтарсан уулзалтын зөвлөмжийг хэрэгжүүлж, орон нутгийн төсөвт НЭМ-ийн чиглэлээр тусгах төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна. | Улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлсэн эрүүл идэвхтэй амьдралыг дэмжсэн арга хэмжээний ажлын үр дүнг тооцсон байна. | АНЭМГ | АНЗДТГ,<br>Аймаг, нийслэл, дүүргийн Иргэдийн хурал,<br>СЯ | ОУБ<br>Эрүүл мэндийг дэмжих сан<br>20 сая |
| 58. | Өглөөний гудамж, эрүүл зөв хооллолтын төв, нэгж, фитнесс төвүүдэд байгууллагад зорилтот бүлэгт тохирсон зохистой хоол бэлтгэх богино | | Сургалтын хөтөлбөр, агуулга, төлөвлөгөөг боловсруулсан байна. | Сургалт зохион байгуулсан байна. | Сургалт зохион байгуулсан байна. | НЭМҮТ | Аймаг, нийслэлийн НЭМТ | Эрүүл мэндийг дэмжих сан<br>20 сая |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хугацааны сургалт зохион байгуулах | | | | | | | |
| **ЗОРИЛТ 5. СЭТГЭЦ, ЗАН ҮЙЛ, ТАНИН МЭДЭХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖСЭН НИЙГМИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 59. | Тамхины хяналтын тухай хууль, тамхины хяналтын суурь конвенцыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн дотоод журамд "Тамхигүй орчин" бүрдүүлэх, ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах | | Тамхигүй орчин бүрдүүлэх санамж, анхааруулгын чанартай контент боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд контентыг таниулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд контентыг таниулсан байна. | НЭМҮТ ХЗДХЯ ХХААЯ | ЭМГ АНЗДТГ | Эрүүл мэндийг дэмжих сан 30 сая |
| 60. | ЭМАШТҮ-нд архи, тамхинаас гарах зөвлөгөө өгөх, сургалтад хамруулах арга хэмжээг хэрэгжүүлэх | Журам, заавар боловсруулж батлуулах | Сургагч багш нарыг бэлтгэх, сургалт явуулах | Сургагч багш нарыг бэлтгэх, сургалт явуулах | Сургагч багш нарыг бэлтгэх, сургалт явуулах | СЭМҮТ | НЭМҮТ, ТББ-ууд | ДЭМБ, Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 61. | ДЭМБ-ын mhGAP аргачлалын дагуу сэтгэцийн тулгамдсан асуудалтай болон эмгэгтэй хүнд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх чадавхийг бэхжүүлэх | | Чадавх бэхжүүлэх сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, сургагч багш бэлтгэсэн байна. | Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна. | Эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатлалын эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ СЭМҮТ | ЭМБ | Хариуцах байгууллагын төсөв |
| 62. | Иргэн өөрөө өөрийнхөө сэтгэцийн тулгамдсан асуудлыг үнэлэх, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх цахим аппликэшнийг хүн амд хүргэх арга хэмжээ зохион байгуулах | | Цахим аппликэшнүүд боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээгээр сурталчилж, СЭМҮТ-ийн 1800-2000 утсаар зөвлөгөө өгсөн байна. | Нийгмийн сүлжээгээр сурталчилж, СЭМҮТ-ийн 1800-2000 утсаар зөвлөгөө өгсөн байна. | СЭМҮТ | НЭМҮТ ТББ | Эрүүл мэндийг дэмжих сан 10 сая |
| 63. | ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш нарт сэтгэцийн эрүүл мэнд ба эрүүл зан үйлийг төлөвшүүлэх арга зүйн чадавхжуулах сургалт | | Сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг хамтран боловсруулсан байна. | Эрүүл мэндийн хичээлийн багш нарт сургаж чадавхжуулах сургалтыг бүсчлэн зохион байгуулсан | Эрүүл мэндийн хичээлийн багш нарт сургаж чадавхжуулах сургалтыг бүсчлэн зохион байгуулсан | ЭМЯ БШУЯ | НЭМҮТ СЭМҮТ | Эрүүл мэндийг дэмжих сан 30 сая |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах | | | байна. | байна. | | | |
| 64. | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний удирдамж боловсруулан, хэрэгжүүлэх | | Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний удирдамж боловсруулсан байна. | Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд сургалт зохион байгуулсан байна. | Сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд сургалт зохион байгуулсан байна. | ЭМЯ ХНХЯ БШУЯ | СЭМҮТ ХБХХЕГ ГБХЗХГ | Хариуцах байгууллагын төсөв<br><br>ОУБ-ын дэмжлэг |
| 65. | Сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, сэтгэцийн эмгэгийн тухай нийгэм дэх ташаа ойлголт, хандлагыг өөрчлөх ухуулга нөлөөллийн арга хэмжээ явуулах | | Мэдээлэл сурталчилгааны материал боловсруулсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | СЭМҮТ | НЭМҮТ ТББ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>10 сая |
| 66. | Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих зөвлөгөө өгөх, сургалт явуулдаг ТББ, олон нийтийн хөдөлгөөнийг дэмжих | | Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих зөвлөгөө өгөх арга зүйн сургалт зохион байгуулсан байна. | Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих сургалт, сурталчилгаа, уулзалтыг хамтран зохион байгуулсан байна. | Архи, тамхинаас татгалзах сэдлийг дэмжих сургалт, сурталчилгаа, уулзалтыг хамтран зохион байгуулсан байна. | СЭМҮТ АНЭМГ ЭМБ | НЭМҮТ ТББ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>30 сая |
| 67. | Архины хэтрүүлэн хэрэглээнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийг судалж, архинаас татгалзах ухуулга нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах | | Архины хэтрүүлэн хэрэглээнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлсийн судалгаа хийж, зөвлөмж боловсруулсан байна. | Баяр ёслолыг архигүй тэмдэглэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | Архинаас татгалзах зан үйлийг дэмжих нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан байна. | СЭМҮТ | НЭМҮТ ТББ | Эрүүл мэндийг дэмжих сан<br><br>20 сая |
| 68. | "Архидан согтуурахаас сэргийлье" мэдээлэл сурталчилгааны цахим аяныг иргэдэд хүргэх, сайн туршлагыг сурталчлах | | Цахим аяны агуулга, шторк боловсруулсан байна. | Цахим аяны мэдээллийг олон нийтэд хүргэсэн байна. | Аяныг амжилттай хэрэгжүүлсэн байгууллага, хамт олны сайн туршлагыг сурталчилсан байна. | СЭМҮТАНЭМГ | АНЗДТГ | Эрүүл мэндийг дэмжих<br><br>30 сая |
| 69. | Сэтгэц, зан төрхийн асуудалтай хүүхдийн хичээлдээ оролцох, нийгмийн оролцоог сайжруулах чиглэлээр олон | | Сургалтын агуулга, арга зүйг боловсруулсан байна. | Цэцэрлэг, ЕБСийн багш нарыг сургалтад хамруулж, ухуулга нөлөөллийн | Цэцэрлэг, ЕБСийн багш нарыг сургалтад хамруулж, ухуулга нөлөөллийн ажил | СЭМҮТ ХБХХЕГ | БШУЯ ХНХЯ | Эрүүл мэндийг дэмжих сан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн ойлголтыг сайжруулах | | | ажлыг зохион байгуулсан байна. | тогтмолжсон байна. | | | 30 сая |
| 70. | Настны сэтгэл засал эмчилгээг өргөжүүлэх | | Сэтгэл засал эмчилгээний удирдамж боловсруулсан байна. | Настны сэтгэл засал эмчилгээ тогтмолжсон байна. | Настны сэтгэл засал эмчилгээ тогтмолжсон байна. | СЭМҮТ Геронтологийн үндэсний төв | ЭМБ | Хариуцах байгуулла гын төсөв |
| 71. | Аймаг, дүүргийн ЭМБ, ЕБС-ийн байгууллагуудад Сэтгэл зүйн баг ажиллуулах | | Сургалтын хөтөлбөр удирдамж, хамрагдах байгууллагын хуваарь батлагдсан байна. | Хамрагдах байгууллагуудтай гэрээ хийж, сургалт явуулсан байна. | Гэрээт сургалт тогтмолжсон байна. | ЭМЯ СЭМҮТ | ЭМБ | Хариуцах байгуулла гын төсөв |
| 72. | Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжигч албан байгууллага, хамт олныг шалгаруулах болзолт уралдаан жил бүр зохион байгуулах | | Болзолт уралдааны удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | Болзолт уралдааны удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | Болзолт уралдааны удирдамж, төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлсэн байна. | ЭМЯ СЭМҮТ | ЭМХТ Мэргэжлийн салбар зөвлөл | Эрүүл мэндийг дэмжих сан 30 сая |
| 73. | Эрүүл мэндийн анхан шатлалд дахь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр сайн дурын идэвхтнүүдэд мэдлэг олгох сургалт явуулах | | Сургалтын агуулга, хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна. | Сургагч багш нар бэлтгэж, нийслэлд сургалт зохион байгуулсан байна. | Сургалтыг орон нутагт бүсчлэн зохион байгуулсан байна. | СЭМҮТ АНЭМГ | НЭМҮТ МУЗН | ОУБ |
| 74. | Хүүхдийн аутизм өвчнийг илрүүлэх сэтгэл зүйн оношилгооны шинэ технологийг нэвтрүүлэх | | Шинэ технологийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх бэлтгэл хангасан байна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлсэн байна. | Шинэ технологийг эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэж, нутагшуулсан байна. | ЭМЯ СЭМҮТ | АНЭМГ | Улсын төсөв 20 сая |
| 75. | Сэтгэцийн тулгамдсан асуудалтай, эмгэгтэй хүнд болон хүн амд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг эрүүл мэндийн шатлал бүрийн байгууллага хийж байх | | Шийдвэр гарган, хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах Орон нутаг, байгууллагуудад сургалт зохион байгуулж эхлэх | Орон нутаг, байгууллагуудад сургалт зохион байгуулах | Орон нутаг, байгууллагуудад сургалт зохион байгуулах | ЭМЯ | СЭМҮТ, харьяа байгууллагууд | ОУБ,ЭМД Сан |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтолцоог ДЭМБ-ын mhGAP аргачлалын дагуу хийдэг болох | | | | | | | |
| 76. | Сэтгэц, мэдрэл, донтолтын тусламж үйлчилгээний нэгдсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалтыг онлайнаар явуулах бэлтгэл ажил хийх, сургалт явуулах | | Онлайн сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулах батлах, сургалтыг эхлүүлэх | Сургагч багш нар бэлтгэж, нийслэлд сургалт зохион байгуулсан байна. | Сургалтыг орон нутагт бүсчлэн зохион байгуулсан байна. | СЭМҮТ АНЭМГ | ЭМХТ Мэргэжлийн салбар зөвлөл | Эрүүл мэндийг дэмжих сан<br>30 сая |
| 77. | Сэтгэц, донтох эмгэгийн эмчилгээнд хэрэглэх орчин үеийн шинэ эм бэлдмэлийг эмчилгээнд нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад оруулах, эмийн хангамжийн төрлийг нэмэгдүүлэх, хангах | | ДЭМБ-ын удирдамжид заагдсан сэтгэц, донтох эмгэгийн эмчилгээний орчин үеийн шинэ эм бэлдмэлийн жагсаалтыг гаргасан байна. | ДЭМБ-ын удирдамжид заагдсан сэтгэц, донтох эмгэгийн эмчилгээний орчин үеийн шинэ эм бэлдмэлийг хангах | ДЭМБ-ын удирдамжид заагдсан сэтгэц, донтох эмгэгийн эмчилгээний орчин үеийн шинэ эм бэлдмэлийг хангах | ЭЭХХЗГ ЭМДЕГ | СЭМҮТ | Эрүүл мэндийг дэмжих сан<br>40 сая |

**Яам, Үндэсний зөвлөл**

БШУЯ- Боловсрол, шинжлэх ухааны яам
ХНХЯ- Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам
ЗТХЯ- Зам тээврийн хөгжлийн яам
БХБЯ- Барилга хот байгуулалтын яам
ХХАХҮЯ- Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
СЯ- Сангийн яам
ЭМЯ- Эрүүл мэндийн яам
ЭМДҮЗ- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл

**Засгийн газрын агентлаг, бусад төрийн байгууллага**

НЭМҮТ- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
СЭМҮТ- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ЭМБ- Эрүүл мэндийн байгууллагууд
ӨСЭМТ- Өрх, сумын эрүүл мэндийн төв
ЭМХТ- Эрүүл мэндийн хөгжлийн төв
ЭМДЕГ- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭЭХХЗГ- Эм, эмнэлгийг хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар
БТСУХ- Биеийн тамир, спортын улсын хороо
БТСГ- Биеийн тамир, спортын газар

ШӨХТГ- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
МХЕГ- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХБХХЕГ- Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХХҮЕГ- Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газар
ГБХЗХГ- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ЕБС- Ерөнхий боловсролын сургуулиуд
АНЗДТГ-Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар
АНЭМГ-Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар
АНБГ- Аймаг, нийслэлийн боловсролын газар
АНБТСГ- Аймаг, нийслэлийн биеийн тамир, спортын газар

**Төрийн бус байгууллага болон бусад**

ХАҮТ- Худалдаа аж үйлдвэрийн танхим
ААН- Аж ахуй нэгж байгууллагууд
ОУБ- Олон улсын байгууллага
МУЗН- Монголын улаан загалмайн нийгэмлэг
ТББ- Төрийн бус байгууллагууд

---o0o---

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 сарын 13 өдрийн А/780 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## “ЭРҮҮЛ ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин 2019 | Хүрэх түвшин (оноор) | | | | Эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| **I.** | **Үр нөлөөний шалгуур үзүүлэлт** | | | | | | | |
| 1. | Хөдөлгөөний хомсдолтой хүн амын хувь (хүйсээр) | хувь | 21,9 | | | | 15,0 | Эрүүл мэндийн үзүүлэлт<br><br>ХБӨ, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа<br><br>Хоол тэжээлийн үндэсний судалгаа |
| 2. | Илүүдэл жин ба таргалалттай хүн амын эзлэх хувь (БЖИ ≥25кг/м2) (хүйсээр) | хувь | 49,4 | | | | 42,0 | |
| 3. | Эхийн сүүгээр дагнан хооллож байгаа 6 хүртэлх сартай хүүхдийн эзлэх хувь | хувь | 47,0 (2018 он) | | | | 70,0 | |
| 4. | Давсны хоногийн дундаж хэрэглээ | грам | 10,5 | | | | 8,0 | |
| 5. | Өдөр бүр тамхи татдаг хүн амын хувь (хүйсээр) | хувь | 21.6 | | | | 18.0 | |
| 6. | Сүүлийн 1 сард согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүн амын хувь (хүйсээр) | хувь | 19,8 | | | | 16,0 | |
| **II.** | **Үр дүнгийн шалгуур үзүүлэлт** | | | | | | | |
| 7. | Бусад салбартай хамтран баталсан эрх зүйн баримт бичгийн тоо | Тоо | | | 3 | 3 | 6 | Үйл ажиллагааны тайлан |
| 8. | Шинээр байгуулагдсан “Эрүүл зөв амьдрал” төвийн тоо | Тоо | | | 9 | 10 | 11 | |
| 9. | Амьдралын хэв маягийн чиглэлээр хийсэн үнэлгээ, судалгааны тоо | Тоо | | | 3 | | 3 | |
| 10. | “Эрүүл идэвхтэй амьдрал” цахим хуудсын хандалтын өсөлтийн хувь | Хувь | Байхгүй | | | 10 хувь | 30 хувь | |
| 11. | Идэвхтэй хөдөлгөөний талаар зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо | Тоо | | | 10 | 11 | 12 | |
| 12. | Эрүүл зөв зохистой хооллолтын талаар зохион байгуулсан сургалт, сурталчилгааны тоо | Тоо | | | 2 | 4 | 4 | |
| 13. | Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлсэн сургалт, сурталчилгааны тоо | Тоо | | | 3 | 5 | 8 | |

--- oOo ---